

“ХАРАНХУЙ ХАД” МОНГОЛЫН АНХНЫ АБСУРД ЗОХИОЛ

Д. Цэнджав *

Их зохиолч Дашдоржийн Нацагдорж Монголын хувьд цагаа олж төрсөн нь азтай явдал ч гэлээ, хувь хүнийхээ хувьд цагаа олж төрөөгүй юм шиг айхавтар будангуйрал харанхуйлал нь амьдралын сүүлийн жилүүдэд тохиолджээ. Оргилсон тасархай авъяас билэг, эзэмшсэн боловсрол, сэхээтэнлиг байдлаараа ховорхон төрөх зохиолчоороо монголчууд бид үеийн үед бахархах ёстой. Бурангуй, дарангуйлагч нийгмийн хар сүүдэр цолгойрсон сэхээтэнд хамгийн түрүү тусаж, ямар ч гэгээ гэрлийг унтрааж чадна. ЗО-аад он бол хэлмэгдлийн эмгэнэл, харууслын хар он жилүүд...Хайран гайхамшигтай оюун билгээ, эрдэнэт хүмүүсээ унтраахын дээдээр унтраасаан. Гаднын гар, коминтерний далавчин дор сагаж, оргиж, төөрөлдсөн зүүнтний ер бусын хэнээрхэл, өвчигнөл, дөвчигнөл, ухаангүй тэнэглэл, хавчлага доромжлол хэрээс хэтэрч байсан үед хамгийн түрүүнээ их зохиолч Д.Нацагдорж өртөж, гүтгэлгэ доромжлол бүхнийг биеэрээ амсжээ. “Хуучны ялзарсан феодал тайж, хөрөнгөтний үзэлтэн, худал цуурхал тараагч, хувьсгалын хэргээс урвагч, ардын засгийн ололтыг жадлан эсэргүүцэгч, Чингисийн үндэсэрхэг үзэлтэн, Зөвлөлт Оросын засгийг үгүйсгэн шүүмжлэгч, хоосон цэцэрхэгч, улстөрийн талаар тогтворгүй этгээд, германы тагнуул, гадаадад зугтахыг санаархагч, архаг архичин, мөнгө хөрөнгөний луйварчин, самуун явдалтан” гэх зэрэг хамаг муу муухай нэр пайзыг зүүж, энэ нь яв явсаар 1932 оны тавдугаар сарын 17-нд баривчлагдан гянданд хорьжээ. Нацагдоржийг 9 удаа эрүүдэн байцаахад, хар амиа бодож хамаг бурууг бусад руу чихэж, нэг ч хүнийг хамсаатан, ардын засгийн дайсан, хувьсгалын эсэргүү гэж гүжирдэж муу үг унагаагүй нь түүнийг ямархан мөс чанартай, хүнлэг, үнэнч шударга нэгэн болохыг илчилнэ. “Үе үе нийлээд архи ууж наргиж цэнгэдэг байсан, хөгжим сонсож дуу дуулж, тав арван төгрөгөөр мөрийтэй хөзөр тоглодог байсан” гэж байцаалт бүртээ ийм нэгэн хэвийн байцаалт өгсөөр байгаад, сүүлдээ орос монголгүй байцаагч нар аргаа баран залхаж мухарджээ. Архи уудаг гэвэл тэр үеийн оросууд шиг, тэр үеийн дарга сайд нар шиг ууж согтуурдаг нь байгаагүй, тоглож наргидаг нь байгаагүй. Түүнийг 5 сар гаруй нохой бөөс бужигнасан гяндангаас арайхийж нэг жилийн тэнсэн харгалзах ял авч хөөгдөж гарчээ. “Ганц үүгээр тогтохгүй шүү, муу хувьсгалын эсэргүүн минь” гэж өшиглөөд гаргажээ. Харин Нацагдорж “Уригдаж ирсэн орос сургагч нар анх нутгаасаа ирэхдээ муу уранхай хувцастай ирээд буцах үестээ сайн сайхан хувцастай болоод явдаг, ...зарим сургагч тустай ажлыг хийх байтугай гагцхүү цалин мөнгөний хойноос хөөцөлдөн буцдаг” гэсэн шударга шулуун мэдүүлэг өгч байсан нь өөрийн хатуу үзэл бодлын илэрхийлэл юм. Тэр үед оросын

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

сургагч, зөвлөх, мэргэжилтэнг шүүмжилбэл мөрөн дээрх хар толгойгүй гэдгийг мэдсээр байтал ийм эрс шулуун хурц шүүмжлэлийг оросын зөвлөх, байцаагчид хэлсэнээрээ өөрийгөө ардын засгийн дайсны дансанд арилшгүйгээр оруулсан юм.

Байцаалтад бас нэгэн зүйлийг нэмж хэлэхэд “Би монгол, орос, герман, англи хэлбичиг мэднэ” гэснээс үзэхэд ямархан ховор сэхээтэн, соён гэгээрүүлэгч, том боловсортон байсныг санан санахад гашуудалтай. Дээр нь манж хэлбичгийг сайн мэддэг төдийгүй, төвөд бичгээр уншдаг, хятадын ярианы хэлийг эзэмшсэн тухай намтарт нь тэмдэглэгджээ. Ийм олон гадаад хэлтэй бичгийн эрдэмт хүмүүн өдүгээ ч тиймчиг олон биш болов уу? Дээрээс нь эх хэлнийхээ бичих найруулах аргад төгс гүнзгий нэвтэрсэн нь хар багаасаа засаг төрийн өндөр алба ажилд зүтгэж, жанжин Сүхбаатарын гарын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан хийгээд бусдад нэг үг, өгүүлбэрийн ташаа сул найруулгын талаар маш хатуу чанд шаардлага тавьдаг, хуучны бичгийн хашир түшмэл “хичээнгүй” хэмээх Ерөнхий сайд Балингийн Цэрэндоржийн дэргэд Нацагдорж хоёр жил ажиллаж, сайдаас “ховорхон хүү, энэ хүүг улам боловсруулах ёстой” гэсэн магтаал сонсож байсан баримт бий.

1925 онд Ленинградын Цэргийн Академид, 1926 онд Берлин хотын Лейпцигт хэвлэл сэтгүүлзүйн сургуульд суралцаад 1929 онд эх орондоо буцаж иржээ. Уран зохиолчоос гадна түүхч, орчуулагч, сэтгүүлч нийтлэлч гэж үзэж байснаа 2016 онд түүний мэндэлсний 110 жилийн ойн эрдэм шинжилгээний хуралд “Толь зүйч, ном зүйч, соён гэгээрүүлэгч” талаар судлаачид баримт түшиглэн сонирхолтой илтгэл тавьсан юм. Үнэхээр олон талтай ховор авъяас билэгтэн байв. Тэрбээр 31-хан наслахдаа ерөөс гол бүтээлээ 6, 7-хон жилийн дотор босон суун туурвиж, энэ завсар монгол хэлний тайлбар толь зохиох, түүх зохиох, “Капиталыг” Цэвээнжамрановын хамт орчуулах гээд тал талаас таталж чангаасан олон ажил байсан ч самгардалгүй, гайхамшигт зохиолоо бичсээр, нэр алдраа Монголын шинэ үеийн уран зохиолд “үндэслэгч” нэрээр мөнхөлж чадсан юм. Энэ бол нэг гайгүй чадварлаг зохиолчийн бараг ганц роман, нэг хоёрхон тууж ч бичиж амжихааргүй хугацаа. Өөрийнх нь шүлэглэсэнээр:

Хувхай царайг минь үзээд
Хуучин нөхөр минь зугтаана
Хулгайч ялтанд тооцоод
Хялайн харах болно
Өнгөт орчлонд явахад
Үерхэх нөхөд олоон
Өмхий зооринд хэвтэхэд
Үтэр орхидог нь үнэээн.

Нарны гэрэлд явахад

Янаг амраг олон

Нарсны ёроолд хэвтэхэд

Ясныг бүү мэд гэх мэтээр “Шоронгийн шүлгүүддээ” гашуудан халаглаж байлаа.

Өдөр бүр дутагдах, гачигдах, өвдөх зовох бүр хамгийн сайн нөхөд нь хүртэл хаяж, сүүлдээ 1936 онд эхнэр Нина Чистяковаг нь амин хайртай хоёрхон настай Ананда-Шири охины хамтаар 11-р сард хөхөө өвлийн хүйтэнд аянчин хөсөгчин дагуулан хүнлэг бусаар хүч түрэн хил рүү гаргаж, төрсөн нутаг руу нь буцаасанд туйлдтлаа шаналж, тарчилж “сүүлнээс өөр сүүдэргүй, сүүдрээс өөр нөхөргүй” мэт ганцаардаж, ганихрахын зовлонг ханатлаа эдэлжээ.

Үүнийг бичигчбээр хэрхэн яагаад их зохиолчийнхоо ийм гашуудалт, эмгэнэлт амьдралыг бичихэд хүрэв гэхлээр “Харанхуй хад” хэмээх өвөрмөц содон өгүүллэгийг бичсэний цаад далд учир хэргийг холбогдуулах гэсэнд байгаа юм. Зохиолч өөрөө энэ өгүүллэгийг бичсэн оноо “1930 он” гэснээс болоод өнөө хүртэл судлаачдыг мухардал, эргэлзээнд оруулаад, янз бүрийн таамаг дэвшүүлэхэд хүрээд байгаа юм. Гэтэл зохиолын үйл явдал, далд үзэл санаа, нэвтрэн илрэх шугам бүр хойтох үедээ хамааралтай болох нь өгүүлбэр бүрээс мэдрэгдэнэ. Эргэцүүлбээс, 1930 онд түүний амьдрал харьцангуй тогтуун, амьдралын ханийн жаргалыг эдэлж, үр хүүхэдтэй болж, улсаас магтаал сайшаал шагнал хүртэж, нийгмийн боловсрол, соёл урлагийн төрөл бүрийн ажилд оролцохгүй юмгүй байлаа. Энэ онд гэрэл гэгээтэй, зугаатай цэнгэлтэй, наргиантай наадамтай, уран бүтээл өөдрөг байсан гэхэд болно. Ийм үедээ засаг төр нийгмээс хатуу харгис цохилт авч, “Харанхуй хад” шиг эгдүүцсэн шинжтэй чөтгөр шулмас шүглэсэн шиг, чонын улиан шиг хүв хүйтэн хөрзгөр, сэтгэл гутам зэвхий үгүүдтэй, утга далдалсан ёр билгийн шинжтэй зохиол хараахан өдөөдөж гарахааргүй байсан гэхэд болно.

1930 оноос хожуу ханилан суусан Нинаг яагаад зохиолынхоо гол баатар болгов, яагаад хиймлээр сэтгэж, “Харанхуй хад” гэгчийг эрэн бэдрэх, хүсэн мөрөөдөх болов? гэсэн асуултад судлаач эрдэмтэн бүр өөрөөр хариулж ирэв. Туурь өгүүллэгт “Нина гэгч нэг залуу цэвэрхэн охин бөгөөд долоон жилийн урьд би түүнтэй хязгааргүй янаглан ханилсан боловч дараагаар хоёр бие уул далайн тэртээ, энтэйд завсарлагдан, сэтгэл зүрх ташаалагдсан билээ” гэсэн нь ханилж гэрлэсэн Нина Чистякова мөнөөс мөн гэлтэй. Хэрвээ 7 жилийн өмнө суусан гэдэгт итгэвэл 1923 онд тэр 17 настай байх агаад энэ үед тэрбээр Пагамдулам гэдэг монголын гоо үзэсгэлэнт, бас таван гадаад хэлтэй сэхээтэн бүсгүйтэй ханилан сууж байсан төдийгүй, оросууд, тэр тусмаа орос бүсгүйчүүд Улаанбаатарт ирж бараг суурьшаагүй байсан үе. Гучаад он гараад л Зөвлөлт оронд суралцахаар явсан монголын сортоотой сэхээтнүүд эх орондоо ирэхдээ тэр үед “моод” болон дэлгэрээд байсан шар үст орос авгай аваад ирэх нь ёс мэт байв. Нинаг анх мөнөөх мундаг сэхээтэн О.Намнандорж ханилан сууж авчраад, хүүхдийг гаргуулахгүй үр мхөндүүлээд байна гэдгээр шалтаглан хардаж, үг хэл нийлэхээ болиод салсаны дараа их зохиолч авч суусан байх юм. Тэгэхлээр энэ зохиолыг 1930 онд бичээгүй, бүр хожуу эхнэр Нинагаа 1936 онд нутаг хүчээр буцаалгаж, мөн тэр ондоо хоёр дахь удаадаа баривчлагдан шорон гянданд орж, улмаар амьдрал нь дампуурах тийшээ хандан, бор дарсанд нэлээд гүнзгий оосорлогдож, сэтгэлээр унан доройтож байх үедээ бичсэн байх гэдэг таамаглал үнэнд ойртоно.

Аман яриа алдаатай, оноотой, бас осолтой худал байх нь илүү. Хэн ч юм бэ дээ нэг нь 1923 онд Улаанбаатараас зүүн урагшаа байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангид Нина гэдэг өөр орос хүүхэнтэй найзалж байсан юм, тэр л байхгүй юу? гэгчхжээ. Гэвч үүнийг одоо хэн тайлах билээ, өнгөрсөн хорвоо...Ер нь зохиолч хүн ямар нэгэн учиг учир шалтгаанаас болоод зохиолоо хэдэн онд бичсэнээ тэр болгон үнэнээр бичдэггүй тохиолдол захаас аван бий. Бас хайрамжгүйгээс ч болоод алдана. Цаагуур нь эргэцүүлбэл, шоронд орж, хэлмэгдсэнээс хойших тэр он цагийг үнэн зөвөөр бичвэл үргэлж өө сэв эрж, мөрөөр нь мөшгөж, мөчийг нь тоолж, тагнаж, туршиж, өчүүхэн ч хазгай гишгэхийг алдахгүй хянаж байдаг орос, монголын чекистүүд энэ “Харанхуй” хад” гэдэг чинь юу юм бэ? манай нийгэм журмын байгууллыг “Харанхуй хад” гэж хэлэв үү? зэргээр тулган тарчлаахад хүрч болзошгүй тул бичсэн огноогоо урагшуулсан байж болох талтай. Өгүүллэгийг “1930 оны 8. 4” гэж бичсэнийг зохиолчийн намтар,

зохиолыг насан туршдаа судалж хамгийн анх түүврийг гаргасны хувьд, хамгийн ойр найзалж нөхөрлөж явсан, яг нэг нутаг усны нэг үеийн хүний хувьд эрдэмтэxn судлаач Б. Содном гуайнхаар бол “Энэ зохиолыг Нинаг хойд зүг явснаас хойш бичсэн тул, 1936 онд бичжээ. Харин уг оныг нааш татаж бичсэн байна” гэсэн нь үнэнд ойртоно гэж үзэж байна.

Д.Нацагдоржийн өмнөх бүх зохиол нь реалист чиглэлтэй, нэвт гэрэлтсэн дүр, тодорхой агуулга, монгол хэлнийхээ яруу тансаг найруулгатай, ер ойлгомжтой үйл явдалтай байсан хэрнээ, яагаад далд утга санаа агуулсан хийсвэр сэтгэлгээний, уран сэтгэмжит зохиол бичих болсон шалтаг, шалтгаан, үр дагавар юу вэ? гэдгээс эрж хайж янз бүрийн санаа дэвшүүлснийг түрүү дурдсан. Тайлагдашгүй зохиол гэж бий, тайлагдахгүй чанараа хадгална гэдэг бол жинхэнэ сонгодог, өвөрмөц сэтгэлгээний далд гүн утгат зохиолын шинжийг агуулсанд байгаа юм. “Харанхуй хад” чухам ямар төрөлд хамаарах, уран зохиолын илэрхийллийн ямар арга барилаар бичсэн зохиол вэ? гэдэгт зохиолч өөрөө хариулжээ. Их зохиолч өөрөө “novelle” хэмээн латинаар бичиж, хажууд нь “Уран сэтгэмжийн өгүүллэг” гэж монгол бичгээр таталгасан байна. Тэгэхлээр герман боловсролтой зохиолч америкийн болон өрнөдийн уран зохиолын өвөрмөц онцлог, түүний дотор реалист бус урсгал чиглэлийг гойд сонирхож “Ийм хийсвэр сэтгэлгээний арга бас байдаг байна” гэдэг ойлголтыг авч, ийм үзэл баримжаалал аль хэдийнэ тогтсон нь Америкийн зохиолч Эдгар Элан По-гийн “Алтан цох” зохиолыг монгол хэлнээ орчуулсан явдал юм. Д.Нацагдорж тэрхүү орчуулгынхаа монгол уншигчдад зориулсан оршилдоо “Эдгар По бол ямагт хүний санаанд оршгүй бэрхтэй зүйлийг бичнэ. Энэ “Алтан цох” хэмээх зохиолд маш нарийн нууц зүйлийг хүний ухаанаар ухаж бодохыг утгачилан зөвхөн өөрийн ухаанаар зохиогоод мөн өөрийн ухаанаар тайлахын хамт шинжлэх ухааны чанарыг илэрхийлсэн” гэжээ. Үүнээс үзвэл “Харанхуй хад” бол хийсвэр сэтгэлгээний буюу абсурд зохиол, монгол “Алтан цох” гэхэд ч болох юм.

“Байхгүй юмыг бодох хэрэгтэй

Ижилгүй юмыг бодох хэрэгтэй

Онцын чухал юмыг бодох хэрэгтэй” гэж тэр тэмдэглэлийн дэвтэр дээрээ тэмдэглэсэн талаар “Нацагдорж судлалыг” үргэлжлүүлэгч Л. Балдан гуай бичсэн байна лээ. Дээрх хэдэн үг бол түүний уран бүтээлийн философи гэхэд болох бөгөөд ерөөс ижилгүй сонин юм бичих хэрэгтэй юм байна гэдгийг гадаадын зохиолчдын бүтээлээс эрт суралцсан нь илэрхий байна. Хийсвэр сэтгэлгээний буюу өнөөгийн бидний модернист чиглэлийн зохиолын талаар ямар ч мэдлэггүй хүн реалист бус зохиолыг орчуулж дийлэх үү? гэсэн асуултыг тавьж болно. Ерөөс “Харанхуй хад”, “Алтан цох” хоёр туурь сүнслэг нууцагдмал байдлаараа, далд чанараараа, хоёулаа ямар нэгэн хачирхалтай утгагүй ч юм шиг зүйлийг эрж хайснаараа, эмх цэгцгүй юм шиг холбоо хэлхээгүй ч юм шиг байдлаараа нэгэн сэжмээр уялдаатай нь мэдрэгдээд байдаг. Судлаачид энэ хоёр уран сэтгэмжийн өгүүллэгийг харьцуулан, уран зохиолын сэдэл нөлөөллийг анхаарч судлан гаргалгаа хийж тайлбал, нэлээдийг шинээр нээж болох байх.

Зохиолч “харанхуй хад” гэгчийг эрж хайдаг бол, “Алтан цохын” баатар Легранд учир учир битүүлэгээр эрдэнэс олохыг хайдаг, “харанхуй хадын” таамаглал дэвшүүлдэг бол нэгэн төрлийн бичээс юуг нуусан таамаглалыг дэвшүүлдэг, нэг нь “харанхуй хад Нина” гэдэг бичгээс цочрол авсан бол Легранд бас үл ойлгогдох тоон тэмдэгүүдээс цочрол авдаг, нэг эмгэн чулуу аваад хүүгийн эрж байгаа газар байх магадгүй гэдэг бол

“Алтан цохын” эмгэн Бишопын Костел хэмээх газрыг мэддэг байж магадгүй зэргээр огт өөр боловч төсөрхүү үйл цөөнгүй байгаа нь тэрхүү абсурд зохиол Д.Нацагдоржид үүдэл санаа болж, үүнийг бичих оюун санаанд цочрол үүсгэж, харилцан нөлөөлсөн байх байх магадлалтай. Зохиолчийн үүдэл санаа янз бүрийн хэлбэрээр төрдөг төдийгүй, бусад зохиолчийн номыг уншаад төрөх нь нэн элбэг. Тиймээс өөрийнхөө зохиолыг “Уран сэтгэмжийн өгүүллэг” гэж тэртээ 30-аад онд байтугай одоо ч наад захын магиструуд ингэж ялгаж, зааглахад бэрх. Энэ нь “Алтан цохыг” орчуулахдаа “Уран сэтгэмжийн өгүүллэг” гэж бичсэнээрээ батлагдаж байна.

“Нацагдорж герман хэл бичгийг сурснаас гадна олон улсын эрт одоогийн түүх, гүн ухаан, европ дахины сонгодог уран зохиол, түүний түүх онолын асуудалтай танилцсан байна” гэж мөнөөх Б.Содном гуай 60-аад жилийн өмнө, жинхэнэ социалист реализм хүчээ авч байх үед хөрөнгөтний Германы сургалттай үеийн зохиолчийн үзэл санааны ертөнцийг онцолжээ. “Харанхуй хад” зохиолчийн анхны хийсвэр сэтгэлгээний туршиц төдийгүй, нэг их төгсжүүлж дахин дахин засвар хийхийг ч анхаараагүй, гар хүрээгүй хувилбараараа байгаа аж.

“Рассказыг өгүүллэг, новеллийг туурь” гэж ялгадаг ч бичлэгийн хэлбэрээр бараг адил төстэй болоод ялгаатай тал бийг эс дурдая. Эцсийн эцэст юу хэлэх гээд байна вэ? гэвэл “Харанхуй хад” хэмээх новелла буюу туурь нь нь гоц хурц үйл явдалгүй, бариад авчихаар биежсэн дүргүй, зохиолын дотоод байгууламж ер тодорхой бус, одооны бидний ойлголтоор жинхэнэ хаос шинжтэй буюу тэр чигээрээ эмх цэгцгүй олон деталиудтай, чухам юуг хэлээд, юуг төлөөлөөд, юуг яаж дүрслээд байгаа нь нууцгай, зүүд манан буданд төөрөлдсөн юм шиг зориудын хачирхалт урансайхны хийсвэр сэтгэлгээний зохиол гэхэд болно. “Хөдөө талын үзэсгэлэн” хэмээх сонгодог өгүүллэгээс өдөр шөнө шиг ялгаатай. “Хазаад авмаар” гэж зохиолчийн уулга алдсан залуу идэр жавхлант арван наймхан настай бүсгүйн төрх байдал, зан ааль зэргийн гоо сайхныг, жинхэнэ монгол зохиолчийн монгол үг хэлээр гайхалтай, хэн ч гүйцэхийн аргагүй уран тансаг зүйрлэл, дүрслэлээр халгисан, өгүүлбэр бүрээс гэрэл гэгээ нэвт гэрэлтсэн зохиол бол тэр. Харин “Харанхуй хад” туурь нь эхнээсээ л энэ гэрэл гэгээ нь мөхсөн, нөгөөх үгсийн сангийн баян тансаглал, хосгүй зүйрлэл, чимэглэлт үгс хов хоосорч, түнэр харанхуй дотуур тэмтчих шиг нэг л цог жавхаагүй будангуйрсан хар бараан өнгө тунарна. Реалист бус зохиолын өнгө будаг гэвэл нь энэ зэвхийрэл.

Сэтгэлийн асар их эрчим бүхий романтик зохиолчийн хийморь сүлдийг юу гутааж,юу бөхөөв? гэвэл тухайн үеийн баруунтан зүүнтнээр ялгарсан, бие биедээ үл итгэсэн дайсагнал, үргэлжийн матаас гүжир гүтэлгэ газар авсан, нам засгийн дээд удирдлагадаа хөдөөний, хотынх гэсэн талцал, боловсролтой боловсролгүй нь гэсэн ялгарал, шинэ хуучны зааг, хэлмэгдүүлэл, баривчилгаа...өглөө ажилдаа яваад орой гэртээ эргэж ирэх нь тодорхойгүй аймшигт тэр нийгэм...Өөрийн гэсэн үзэл бодолтой хэрийн хүн зохицож амьдрах хэцүү тийм харанхуй нийгэм нэгэн хэсэгтээ сүрхий батаар тогтсоныг түүх мэднэ.

“Харанхуй хад” тархи оюуны болоод дотоод ертөнцийн хямрал, үймрэл буужигнаан, сэтгэлийн шуурга, тогтворгүй санаашралын хүйтрэл, харанхуй бөгчим агаартай ерөөс манай Монголын уран зохиолын анхны реалист бус абсурд зохиол гэдгийг л хэлэх санаа аль эрт 20-иод жилийн өмнө төрсөнөө өнөөдөр тайлж хэлж байгаа минь энэ. Энэ бол далд санааны агуулгаараа бол “Харанхуй хад” бол монгол хэлбэрийн “Алтан цох” гэдгийг давтмаар байна. Тэрбээр сонгодог философийн эх орон болсон Германы уран зохиолыг зүгээр уншаад өнгөрөх биш, дотоод гүн бүтэц, байгууламж, далдын далд

сэтгэмжид чухам юу оршиж байна гэдгийг зөнч сэтгэхүйгээрээ тайлсан агуу соён гэгээрүүлэгч юм.

Энэ өгүүллээрээ ерөөсөө тэр нь тэрийг төлөөлж байгаа зэргээр таамаг санааг дэвшүүлээд, дэвшүүлээд үнэнийг нэг тийш болгох бололцоогүй мэт. Гэвч ингэж таамаг дэвшүүлнэ гэдэг бол “Харанхуй хад судлалын” хөгжил хөдөлгөөн, сонирхолтой судлагдахуун мөн учраас хойшид ч янз бүрээр өөр өөрийн үзлээр, өөр өөрийн мэдрэмжээр, өөр өөр харааны өнцгөөр тайлбарлах нь үргэлжид нээлтэй байх нь зүй. Зохиолчийн бүтээлийн үүдэл санааг зохиол өөрөө л мэдэхээс хажуугаас нь хэн нэгэн мэргэд өмнөөс нь тийм гэж тайлахад бэрх. Тэр чигээрээ дотоод сэтгэлийн үл ойлгогдол, үүнд шүүн шийдвэрлэгч бараг байх бололцоогүй мэтээр бодогдоно.

Үнэндээ өчүүхэн миний бодлоор бол “Найман сарын гучны бямба гариг, харанхуй хад Нина (Ина) хэмээх хэдэн үсгийг тэмдэглэсэн байх нь утга учир тодорхой үгүй юун тухай бичсэн нь огт мартагдсан тул, дахин нэг удаа алгуурхнаар уншиж эцсийн үсэг дээр хүрвээс Нина хэмээх миний хуучин амраг охины нэр, цахилгаан адил хоромхон зуур миний тархины дотор гэрэлтсэн бөгөөд...гэхчилэн цааш явна. Нина (Ина) –гийн эрэлд явна. Үүнийг янз бүрийн таамаглал дэвшүүлж болох ч зохиолчийн дотоод оюун санааны хий бодлын тэнүүчлэл юм. Энэхүү оюуны санааны тэнүүчлэл нь магадгүй чөлөөт уран бүтээл, чөлөөт тайван аялаг амьдралын эрэл хайгуул юм. Зохиолчийн хэвийн амьдралыг бусниулсан зүүнтэн, баруунтаны гуйвуулга, коминтерний хийрхэл хэлмэгдүүлээр дүүрэн ардын нэртэй боловч эзэрхэг засаглалыг “Харанхуй хадаар” төлөөлөн илэрхийлсэн зүгээр нэг аж амьдрал, ахуйн энгийн эгэл реалист зохиол биш, цаанаа улстөрийн гүн гүнзгий агуулга шинжтэй эмгэнэлт зохиол, бүр нарийвчилбал, Германд эзэмшсэн сэтгүүлзүйн мэргэжил нь үе үе гэрэлтэж гялалзсан, сэтгүүлзүйн нийтлэл - уран зохиолын хосолмол шинжтэй уран найруулалт-тэмдэглэл зохиол ч гэж үзэж болмоор бодол төрнө.

Энэхүү морь унаад цөл, гол ус, салхи бороо, цас шуургийн дунд яваад байгаа нь яг бодитой үйл явдал биш, Нацагдоржийн оюуны зүүд мэт шаналант хий бодол санаа, эргэцүүлэл сэтгэмж юм. Шаналант тэнүүчлэл бол нийгэмд шаарлагдсан гадуурхагдсан зохиолч хүн хог буртаг, бузар муухайгаас зугтан, гэрэл гэгээнд бэдрэхийг хязгааргүй хүссэн хэн нэгний хэлснээр уран бүтээлчийн “зоргоор зорчих дарвуулт завь” мэт хязгааргүй эрх чөлөөнд тэмүүлсэн зохиолчийн эрэл, уран бүтээлчийн дотоод сэтгэлийн эрэл хайгуул мэт юм даа гэж үзэгчийн хувьд надад бууж байв. Нэг үеийн зохиолч С. Буяннэмэх “Харанхуй засаг” гэсэн жүжиг бичсэн. Тэр нь манжийн төр байлаа ч хэрэг дээрээ зохиолчийн доторх санаагаар бол аль ч үеийн ямар ч төр байж болно. Энэ хоёр сонгодог зохиолч яагаад хоёул, хоёулаа “ХАРАНХУЙ” гэдэг үгийг ижилхэн давтаад байв? гэдэг нь сонин.Е рөөс далд утгат, далд санаа зохиолын үзэл санааг С.Буяннэмэх өөрийн онолоороо гаргаж ирснийг 70 жилийн турш шүүмжилж буруутгаж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Нацагдорж хоёр удаа баривчлагдаж, 1935 оны нэгдүгээр сарын 23-нд бичсэн өргөдөлдөө “...сүүлийн үед тамир тэнхээ нэн сул болж, зүрх ба судас мэдрэлийн өвчинд нэрвэгдэн, ажил хийхэд хүчин чадал гарган чадах нь нэн дорой болсон” гээд гурван сарын хугацаагаар СССР-т явуулж, боловсронгуй эмч ба аргыг хүсэж байжээ. Зохиолчийн хувьд “Харанхуй хад” “Харанхуй ангал” болсон харанхуй засгаас хэрхэн түр ч гэсэн зайлж, эрх чөлөөт эрүүл нийгмийг хүсэмжилсэн эрж тэнүүчилсэн дотоод оюуны зөрчил, бясалгал, шанал зовлонгийн цусаар бичсэн шиг ерөөсөө туждын эрэл юм гэж таамаглана.

Ер нь сэтгэл санааны дарамт, хэвийн бус байдал, шаналал, оюун санааны эрүүл бус сэтгэлзүйн дэн дун хий хуй буюу хагас солиорлын эсийн үсэрхийллээс абсурд зохиол үүсдэг нь дэлхийн сонгодог зохиолчдын наад захын жишээ харуулдаг. Дээрх өргөдлөөс ажвал “мэдрэлийн өвчинд нэрвэгдэн” гэж байгаа нь айдас хүйдэсээс болоод тархи мэдрэлийн хэдэн сая живаа эд эс “вирусдэж” түүнээс үүдсэн мөн л “вирусдсэн” ой дурдатгал, ойлголт тусгал, сэрэл мэдрэмж, хүртэхүй төсөөлөл бол өмнөхөөс огт өөрөөр “сэрсэний” үр дүн “Харанхуй хад” туурийн төрөгдөл мөн. Утга далдалж бичсэн нийгэм улстөрийн агуулгатай зориуд төөрөгдүүлэх аргаар туурвисан абсурд зохиол гэдгийг зохиол гэдэг нь үйлүүд цааш өрнөх бүр итгэл үнэмшил төрнө. Эрлийн чиг хаашааг үл мэдэх тэр мориныхоо жолоог сул тавин, түүний аясаар зүг чиггүй зоргоороо явж байгаа нь зохиол эхлэлээсээ л учир шалтгаанаа хэлж байгаа биш үү? Оюут хүмүүнийг дарлагч ямархуу хэрцгий засаг төрд хувь тавилан нь зад үсрэн өөрийн гэх эрх мэдэлгүй жолоо цулбуургүй болж, түүний ирээдүй бүдгэрэн сохорч, бүх юмс дэвс дэмээ алдан буруугаар эргэж, хар толгойгоо мэдэх ямар ч чадамжгүй хяхагдаж, зохиолчийн амьдрал тэр чигээрээ зогсох мэт болж байгааг илтгэнэ. Энэхүү сэтгэлийн гүн хямралыг “...сэтгэлийн дотор гулин галин байдлыг төрүүлнэ” гэдэг үгээр зөвхөн нэг удаа ил гарч, өөрийнхөө таашгүй сэтгэлийн хямралыг илчилжээ. Энэхүү эмгэнэлт хувь заяатай зохиолчийн эмгэг тархи сэтгэлгээнээс өөрөөр хэн ч ийм үгийг бодоод хэлчихээргүй “Галин гулин” гэдэг хэлцийг давтаж чадахгүй. “Гулин галин” гэдэг нэн таагүй байр байцыг заасан холбоо үгийг зохиолч хэлье гэсэндээ хэлээгүй, ерөөс түүний дотоод сэтгэлзүйгээс л гэнэ сэрэггүй өөрөө унажээ.

“Тэртээ хажуу дор нэгэн амьтан явна.Ойртвоос үнэг буюу чоно буюу алин нь танигдах үгүй нэгэн амьтан цааш зугтана гэх. Ийм учир утгагүй дүрс, өгөгдөл нь абсурд зохиолд гэнэт гарч ирдэг, тэр л жамаар гарч ирж байна. Энэ үнэг чоно ч гэмээр амьтсаар юуг төлөөлөв? Нөгөө л оросуудтай, найзуудтайгаа епроп ёсоор шинэ жилийг анх тэмдэглээд дуу хуур, наргиан цэнгээн, архи дарсны хөөрлийн дунд гэм зэмгүйгээр тачигнатал инээгээд авсан гэрэл зургийнхаа ард талд “Тайж Нацагдоржийн банкет” гэж бичээд До яаманд матсан “найзууд” бас Нацагдоржийн зохиолын эх бичгийн нарийвчилсан судалгаа хийж, тайлбар сэлтээр баяжуулсан эрдэмтэн Дожоогийн Цэдэв гуайн зохиолчийн намтарт шинээр салхи оруулсан “Энд Нацагдоржийн удирддаг Германы тагнуулын баг хуралдаж байна” хэмээн бас л нөгөөх До-д матсан “найзуудын” дүр төрх мөнөөсөө мөн гэж тархинд бууна. Дан хар дарсан зүүд адил зөн совин, билэг ёр... Нөгөө нохой буюу найз нар нь гэж болохууд нь дагуулсаар нэг муу хар овоохойн гадаа ирж байна. Хар гэрийн доторх байдал, эд өлөг, учир үл олодох дүрслэл элбэг. “Хар хүн нурманд шигтгэсэн домботой цайг нэг тэвш тарваганы махны хамт надад өгсөнд цай нь гудамжны шалбааг шиг булингартай, мах нь халшгүй нэхүүн үнэртэй” гэжээ. Ахуй байдал, доторх хүмүс...Энэ деталь бол яахын аргагүй нохос мэт “найзуудынхаа” матаасаар хоёр удаа хаалгыг нь татсан шорон гянданг хэолж байна гэсэн ойлголт шууд тархинд бууна. Шоронгийн доторх харгислал байцаалтыг “Ширүүн салхинд модны мөчир гуйвалзан шуугиж, аянгын дуу сүртэй хүржигнэнэ. Энд тэнд чоно улих, бас л тас няс хийх чимээ гарах нь айшигтай. Бие зарайна.... Зорьсон хэрэг ба шинжлэх явдлыг хэдийнэ мартаж гагцхүү амиа хамгаалж явахыг урьтал болгов. Угаас шалгадаг ухааныг шүтэж, боловсронгуйгаар хүмүүжсэн боловч буг чөтгөр гэдэг дэмий юм санагдаж, эрлэг тамын орон гэдэг худал юм бодогдоно” гэж дүрсэлжээ. ...Буцья гэвэл замаас нэгэнт төөрчээ. ...Даруй мориноосоо бууж суун түмэнтээ цочиж, мянгантаа хирдхийн хэзээ нар мандахыг хүлээнэ...Орчлонгийн түмэн амьтны дунд далдарсан хайрт Нина

миний сэтгэлд зурсхийн үзэгдэвч түүний биеийг олж би дахин уулзаж чадахгүй болсон болов уу?...Энэ бол зохиолын төгсгөл хэсгүүд. Өгүүлбэрүүдийг нэг бүрчлэн утгачилан ажиглавал Д.Нацагдорж зохиолчийн цаашаа өөдлөн явах амьдралын зам улам бүдгэрч төөрөлдсөн тухай, энэхүү шорон гяндан мэт харагдаж тусгагдсан “Харанхуй хад” болтолоо зохиолчид төрөгдсөн хэлмэгдүүлэгч харгис нийгэм өөрчлөгдөх болов уу? гэсэн горьдлогыг “хэзээ нар мандахыг хүлээнэ” гэсэн итгэлгүй горьдлогоор илэрч байна. Хайрт Нинатайгаа дахин уулзаж чадахгүй болсон болов уу? гэсэн нь цаашид амьд явах хоногийн тоо дуусах нь ээ гэдгийг зохиолчийн ер бусын мэдрэмжээр зөгнөжээ.

Төгсгөлд нь тэмдэглэхэд, өөрийн амьдарч яваа 30-аад оны нийгэм улстөрийн байдлыг “Харанхуй хад” мэтээр төсөөлж, их зохиолч сэтгэл санаа, оюун тархиараа доройтож “мөхсөн” мэт үедээ зохиогчийн сэтгэлзүйн хямралаас урган гарсан хамгийн адармаатай, хамгийн гүн сэтгэмжтэй, хамгийн хийсвэрлэхүйн орон зайд “үрээ цацаж” төрсөн үнэхээр дотоод ертөнцийн уран сэтгэмжит зохиол болно. Судлагч, уншигч аль ч өнцөгөөс нь харж, яаж ч тайлж, тайлбарлаж болохоор бичсэнд их зохиолчийн ур чадварын ид шид мөн боловч бас өөрөөр зохиолч нэг их хүчилж, нэг ихээр бодон төлөвлөж, үг өгүүбэр бүрээ хянаж шахаж хийсэнд биш реалист бус зохиол төрдөг үүсгэл нөхцөл болсон жолоодлогоо алдсан тархины сэтгэцийн нууц оршино. Манайхны 20-иод ахмад, дунд, залуу үеийн эрдэмтэн судлаачдын оюуныг шавхаж, өөр өөрийнхөөрөө энэ өгүүллэгийн далд утга санааг, дотоод сэтгэлзүйг, зохиолчийн ертөнцийг үзэх үзлийг тайлах гэж хичээсээр ирсэн хамгийн мөлжүүртэй зохиол юм. Энэ өгүүллэгийн талаар өөрийн таамаг, санал бодлоо дэвшүүлсэн тэр бүх судлаач, зохиолчийн өгүүллийг нэг боть ном болгоод гаргачихвал хүн болгоны дэвшүүлсэн санаа гаргалгааг хооронд нь харьцуулаад нэгэн оновчтой мэргэн тайлалд хүрч болох юм даа гэж өчүүхэн би дотроо маш их боддог боловч үүнийгээ гүйцэлдүүлэх мөнгө санхүүгийн болоод чадал чадвар, зав бололцоо даанч үгүй тул хэн нэгэн ухаалаг нь, бэл бэнчинтэй нь, аль эсвэл уран зохиолын нэгэн байгууллага, эрдмийн хүрээлэн нь үүнээс санаа авч биелүүлэх цаг ирэх болов уу? гэж горьдоно. “Олны олон цэн” гэж бий. Нэгэн жижиг горхи урсан урссаар гол мөрөн, далай тэнгис болдогийн адилаар тэр бүхний оюун санааны сувдыг түүн түүсээр үндэстэний хэмжээний их зохиолчийн реалист бус аргаар бичсэн анхны зохиолыг тайлж болох юмаа.

Монгол үндэстэний хэмжээний аугаа зохиолчийнхоо лабораторийг шинээр нээн илрүүлэх цаг болжээ. “Социалист реализмын эхийг тавигч, социалист реализмыг баримталсан зохиолч, хувьсгалт реализмын нэрт төлөөлөгч” гэж социализмын үеийн үзэл суртлыг наан хамаатуулан орчин үеийн уран зохиолын судалгаа, түүхэнд тодорхойлж ирсэнийг эрхбиш өөр нүдээр харах бололцоо чөлөөт нийгэмд нээгдэж байна. Их зохиолчийнхоо урланд нэвтрэн орж, туурвилзүйн өөр хэв маяг, өөр хэлбэр, арга туршиц, дотоод мөн чанар, үзэл бодлыг нийтгэн улам чамбайруулан судалж, сэрэл мэдрэмж, тархины гажиг тусгал, зөн билэг, зүүд совин, ёр бэлгэдэл, дотоод ертөнцийн хямрал бүхнийг хаос шинжээр харуулсан “Харанхуй хад” зохиолыг өвөрмөц түвшинд авч үзэх шаардлагатай санагдана.

Энэхүү содон хэлбэртэй, шинэ өвөрмөц хийц, шинж төрхөөрөө яахын аргагүй Д.Нацагдорж бол модернист чиглэлийн абсурд зохиолын үндэслэгч гэдгийг Монголын уран зохиолын судлал зөвшөөрч, түүхэн бичлэгтээ энэ санааг шинээр оруулж ирвэл нэгэн цагийн төөрөгдөл, ерөөсгөл гажиг ойлголт, зөвхөн нэг талаас харж тодорхойлж ирсэн туйлшралыг өөрчлөх нь Монголын их уран зохиолын хөгжил, оюун сэтгэлгээний даяаршилын эрх ашигт бүрнээ нийцнэ гэсэн бодол санаа төрсөнөө тэмдэглэе.